

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН
2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**


2025 оны 03 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн нийт байгууллага, хэлтэс нэгжийн хэмжээнд 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 3 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 803 өргөдөл хүсэлт ирсэн. Үүнээс хугацаандaa шийдвэрлэгдэж хариу өгсөн 725, судлагдаж байгаа 78 өргөдөл хүсэлт байна. Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 4 өргөдөл хүсэлт байгаа бөгөөд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 90.00 хувьтай байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног 20 цаг 31 минут байна.

**Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ /2025 оны 1
дүгээр улирал/**



2025 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс 3 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд өргөдөл хүсэлтийг өдөрт нь багтаан хүлээж аваагүй, өдөрт нь багтаан шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй болон бусад 318 зөрчил бүртгэгдсэн байна.

Өргөдөл гомдлыг хандалтаар нь авч үзвэл:

- Санхүү татварын тухай - 87
- Нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагааны тухай-73
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тухай-40
- Хоёр дахь шатлалын эрүүл мэндийн тусlamж
үйлчилгээний тухай-36
- Өрхийн эрүүл мэндийн тусlamж үйляилгээний тухай-35
- Газрын маргаантай асуудлыг шийдвэрлэх тухай-34
- Газар чөлөөлөх тухай -30
- Ажлаас чөлөөлөгдөх тухай-28
- Ажилд орох тухай -25
- Бусад 415 өргөдөл хүсэлт байна.

Өргөдөл гомдлын мэдээ тайланг улирал, сар болон 7 хоног бүр гаргаж дээд шатны байгууллагад тайлагнан Дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурал хурлаар хэлэлцүүлэн ажиллаж байна.

Дээрх хугацаанд 4 өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн байна.
Сүхбаатар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал-1, 225-р цэцэрлэг-2,12-р хороо-1

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2025 ОНЫ 1 ДУГЭЭР УЛИРЛЫН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2025 оны 03 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 161 өргөдөл хүсэлт ирсэн. Үүнээс хугацаандаа шийдвэрлэж хариу өгсөн 142, судлагдаж байгаа 19 өргөдөл хүсэлт байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 90,00 хувьтай байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 21 цаг 42 минут байна.

Дээрх хугацаанд өргөдөл хүсэлтийг өдөрт нь багтаан хүлээж аваагүй, шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй гэх мэт 5 зөрчил бүртгэгдсэн байна.

Уг зөрчлийг бууруулах тал дээр анхаарч ажиллах талаар албан хаагч бүрт өдөр тутамд мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Өргөдөл	гомдлыг	хандалтаар	нь	авч	үзвэл
	Дүүргийн Засаг даргын бодлого үйл ажиллагааны тухай-11				
	Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааны тухай-11				
	Орон сууцны лифтний ашиглалт, засвар үйлчилгээний тухай-8				
	Хүүхэд үрчлэлийн асуудал-7				
	Гэрэлтүүлэг чимэглэлийн тухай-7				
	Бусад-98				

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:
Тохижилт нийтийн аж ахуйн чиглэлээр:

Тус хэлтэст 2025 оны 1-3 сарын хугацаанд 83 иргэнээс өргөдөл гомдол санал хүсэлт ирүүлсэн байна.

Үүнээс иргэний 83 өргөдлийг ажлын 1-10 хоногийн хугацаанд шийдвэрлэж, өргөдөл гомдол санал хүсэлтийг хуулийн хугацаанд судалж байна.

Шийдвэрлэлт 94% үзүүлэлттэй байна.


- Хүрээлэн буй орчин тохижилт үйлчилгээтэй холбоотой 47 өргөдөл
 - Зам тээвэр, дэд бүтэц, инженерийн байгууламжийн тухай 9 өргөдөл
 - Орон сууц нийтийн аж ахуй, сууц өмчлөгчдийн холбооны тухай 22 өргөдөл
 - Төрийн үйлчилгээ, төрийн байгууллагын үйл ажиллагааны тухай 5 өргөдөл
- 1.Хүрээлэн буй орчин тохижилт үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдол

2025 оны эхний 1 дүгээр улиралд ил, задгай хог хаягдал, түүвэр хогийг цэвэрлэх иргэд аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 22,23-ны өдрүүдэд бүх их цэвэрлэгээний ажлыг зохион зохион байгууллаа.

Бүх нийтийн их цэвэрлэгээний хүрээнд дүүргийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ хариуцсан 4 байгууллагын 119 зам талбайн үйлчлэгч, 4 тусгай зориулалтын машин техниктэй дүүргийн нийтийн эзэмшилийн 775000м.кв талбай, нийтийн эзэмшилийн нийтийн эд хогшил буюу 12 автобусны буудал, 125 ширхэг тэмдэг тэмдэглэгээ, 1053 у/м хайс, 209 ширхэг хогийн сав, 46 сандал, 3 хөшөө дурсгалыг зориулалтын бодис ашиглан угааж цэвэрлэн, явган зам, авто замын нуух, ханаас хана хоорондын цэвэрлэгээг хийж гүйцэтгэлээ.

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 2342 аж ахуй нэгж байгууллагын 5022 ажилтан албан хаагчид, 203 сууц өмчлөгчдийн холбоодын 260 ажилтан цэвэрлэгээнд оролцож 88915м2 талбайн хог хаягдал, хар цас ачилт, ногоон байгууламж, тоглоомын талбайн цэвэрлэгээг хийж цэвэрлэгээнээс гарсан 260тонн хог хаягдлыг 75 рейсээр ачиж тээвэрлэсэн.

Цэвэрлэгээний явцад Засаг даргын тамгын газрын 62 ажилтан албан хаагч болон, Эрхэм иргэдийн оролцоот хяналтын төрийн бус байгууллага, Иргэдийн оролцоот ногоон байгууламжийн хяналтын зөвлөл, Ганган тогос ТББ-ын ажилтан албан хаагч нар хяналт тавьж ажиллалаа.



2025 оны 01 дүгээр сард дүүргийн 1-20 дугаар хороодын айл өрх, аж ахуй нэгж байгууллагын хог тээврийн нарийвчилсан хуваарийг Дүүргийн менежерээр батлуулан Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар тохижилт ХХК, Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-н цэвэрлэгээ, үйлчилгээний ажилд Хороодын олон нийтийн байцаагч нараар байнгын хяналт тавьж байна.

Хог хаягдлын тухай хууль, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн ханган Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар тохижилт

ХХК, Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-н цэвэрлэгээ, хог тээвэрлэлтийн үйлчилгээг тогтол хийлгэн иргэнд хариу мэдэгдэн ажиллаж байна.



Нохой устгалыг "Их булаг" ХХК хороодоос ирсэн дуудлагын дагуу өдөр бүр хийж гүйцэтгэж байна.

Дүүргийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/101 дүгээр захирамжаар 2025 оны 03 дугаар сарын 24, 25, 04 дүгээр сарын 07, 08, 09-ны өдөр эзэнгүй нохой муурны тоог бууруулах, орчны аюулгүй байдлыг хангах эрчимжүүлэх арга хэмжээний хуваарийг гарган 03 дугаар сарын 24-ний өдөр 199 нохой, 11 муур, 25-ны өдөр 157 нохой, 11 муур нийт 356 нохой, 22 муурны тоо толгойг буурууллаа.



2.Зам тээвэр, дэд бүтэц, инженерийн байгууламжийн тухай өргөдөл, гомдол

Зам тээвэр, дэд бүтэц, инженерийн байгууламжийн тухай ирсэн санал, хүсэлт гомдлыг шийдвэрлэхдээ Нийслэлийн шуурхай удирдлагын төв, Нийслэлийн замын хөгжлийн газар, Улаанбаатар зам засвар ОНӨААТҮГ болон мэргэжлийн инженерийн байгууламж хариуцсан байгууллагад тухай бүр албан бичиг болон хариуцсан дуудлага хүлээн авах төвд дуудлага өгч засвар үйлчилгээнд хяналт тавин иргэнд хариу мэдэгдэн ажиллаж байна.

3.Орон сууц нийтийн аж ахуй, сууц өмчлөгчдийн холбооны тухай өргөдөл гомдол

Орон сууц нийтийн аж ахуй, сууц өмчлөгчдийн холбоотой гомдлыг Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн эд хөрөнгийн тухай хуулийн дагуу газар дээр нь очиж тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн ажилласан.

Үүнд: -Хог тээвэрлэлт

-Гадна орчны цэвэрлэгээ, үйлчилгээ

-Төлбөр үндэслэлгүй нэмсэн

-Хүүхдийн тоглоомын талбайн засвар үйлчилгээ

-Тайлангийн хурлаа хийхгүй

-Лифт ажиллахгүй байгаа, шинээр тавиулах

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 2 дугаар хороо 44 дүгээр байр, 6 дугаар хороо 31 дүгээр байр, 11 хороо 52 дугаар байрны лифтийг шинэчлэхээр гүйцэтгэгчтэй гэрээ байгууллан ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.

Иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу гэрэлтүүлгийн ашиглалт хариуцсан байгууллагад утсаар мэдэгдэх мөн албан бичгээр хандаж засварлуулах ажлыг зохион байгуулж байна.



Дүүргийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн 6444 ширхэг гэрэлтүүлгийн арчлалт хамгаалалтыг Гэрэлтүүлэг чимэглэл ХХК, Спейшл тим ап ХХК, БМЖЛ ХХК-иуд хариуцан ажиллаж байна. Гэрэлтүүлгийн асалт, арчлалт хамгаалалтын ажлын гүйцэтгэлийг гэрээнд заасан нөхцлийн дагуу сард 3 аас доошгүй удаа хяналт шалгалтын

ажлыг зохион байгуулж, иргэдээс ирүүлсэн мэдээллийн дагуу засвар үйлчилгээг тогтмол хийж байгаа бөгөөд гэрэлтүүлгийн асалт 98,9%-тай байна.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны А/15 дугаар захирамжаар 2025 оны 01 дүгээр сараас хороо тус бүр дээр 2 иргэдийн бүлгийн ажилчид сар бүр урамшуулал авч хорооны нутаг дэвсгэрийн ил задгай түүвэр хог хаягдлыг цэвэрлэн ажиллаж байна.



Дүүргийн 1-20 дугаар хорооны нийтийн эзэмшлийн 222 байршлын 1.217.000м² зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ, Сүхбаатар тохижилт ХХК хийж ажлын гүйцэтгэлд сард 4-5 удаагийн давтамжтайгаар хяналт тавин ажиллаж байна.



Хог хаягдлын тухай хууль, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн ханган Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар тохижилт ХХК, Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-н цэвэрлэгээ, хог тээвэрлэлтийн үйлчилгээг тогтмол хийлгэн иргэнд хариу мэдэгдэн ажиллаж байна.

4. Халиа дошин, шар усны үертэй хобоотой асуудлаар

2025 оны 1 дүгээр улиралд дүүргийн 15, 16, 18, 19, 20 дугаар хороодод 4800 м урт далан суваг татаж 8600м³ мөс зөөж тээвэрлэн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж ажилласан.



Нийгмийн хөгжлийн чиглэлээр хийгдсэн ажлуудаас:

Тус хэлтэст нь 2025 оны байдлаар <https://erp.ulaanbaatar.mn/> өргөдөл, гомдлын системээр 35 өргөдөл, хүсэлт хүлээн авч ажиллаж байна. Үүнд:

№	Өргөдөлийн утга	Нийт ирсэн өргөдлийн тоо	Үүнээс	
			Хугацаандаа шийдвэрлэсэн	Хүлээгдэж байгаа
1.	Хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох тухай	6	6	
2.	Хүүхдэд үрчлэлт тогтоох тухай	10	9	1
3.	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд харгалзан дэмжигч тогтоох тухай	5	5	
4.	Гэр хүссэн	3	1	2
5.	Буцалтгүй мөнгө, яаралтай тусламж, эмчилгээ, нийгмийн халамж хүссэн	5	3	2
6.	Тэмцээний зардалд дэмжлэг хүссэн	1	1	
7.	Гомдол	5	5	
	Нийт	35	30	5

Өргөдлийг шийдвэрлэлтийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулахад:

№	Өргөдлийн утга	Шийдвэрлэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

1	Хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгоо тухай	Иргэдээс ирүүлсэн 6 өргөдлийг хянаж үзэж, дүүргийн Засаг даргын 2025 оны Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоо тухай A/04, A/10, A/42, A/45, A/62, A/82 дугаар захирамжуудыг гарган, асран хамгаалагч, харгалзан дэмжигчидтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
2	Үрчлэлт тогтоо тухай	Иргэдээс ирүүлсэн 9 өргөдлийг хянан үзэж, дүүргийн Засаг даргын 2025 оны Хүүхдэд үрчлүүлэх тухай A/02, A/05, A/07, A/12, A/23, A/24, A/25, A/63, A/78 дугаар захирамжуудыг гаргаж, дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн.
3	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд харгалзан дэмжигч тогтоо тухай	Иргэдээс ирүүлсэн 4 өргөдлийг хянаж, дүүргийн Засаг даргын 2025 оны харгалзан дэмжигч тогтоо тухай A/06, A/51, A/88, A/89 дугаар захирамжуудыг гарган асран хамгаалагч, харгалзан дэмжигчидтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. - Л.Юлээйд дүүргийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн A/218 дугаар захирамжаар харгалзан дэмжигч тогтоосон бөгөөд захирамжийн хүчинтэй хугацаа 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр хүртэл хүчинтэй тул Юлээйгийн харгалзан дэмжигч Ю.Нямжавд тус захирамжийн хуулбарт хуулбар үнэн тэмдэг даран өгч өргөдлийг шийдвэрлэсэн.
4	Гэр хүссэн	Гэр хүссэн 1 иргэний өргөдлийг хүлээн авч харьялал бүхий хорооны ажлын албаар нөхцөл байдлын үнэлгээ хийлгэн дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцүүлэн гэр олгосон. Үүнд: 1. Дүүргийн Засаг даргын 2025 оны 02 дугаар 12-ны өдрийн A/52 дугаар захирамжаар 19 дүгээр хорооны иргэн Г.Адъяадуламд 5 ханатай иж бүрэн тавилгатай, давхар дулаалгатай гэр олгохоор шийдвэрлэн гэрийг барин гардуулан өгсөн.
5.	Буцалтгүй мөнгө, яаралтай тусlamж, эмчилгээ, халамж хүссэн	Буцалтгүй мөнгөн тусlamж, эмчилгээний зардалд дэмжлэг хүссэн 2 иргэний өргөдлийг хүлээн авч, харьялал бүхий хорооны ажлын албаар нөхцөл байдлын үнэлгээ хийлгэн, өргөдлийг дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар орж хэлэлцүүлэн мөнгөн тусlamж олгосон. Үүнд: 1. Засаг даргын 2025 оны 02 дугаар 12-ны өдрийн A/53 дугаар захирамжаар иргэн Н.Төвшиндоржийн эмчилгээний зардал 3,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2. Засаг даргын 2025 оны 02 дугаар 17-ны өдрийн A/67 дугаар захирамжаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн Ж.Уснакад хөдөлмөрлөх, үйлдвэрлэл эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэн 3,000,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусlamж үзүүлсэн.
	Тэмцээний зардалд дэмжлэг хүссэн	Гимнастикийн шугаман бүжгийн холбооноос 2025 оны 02 дугаар сарын 07-ний өдөр зохион байгуулагдах шугаман бүжгийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг

6		тамирчдад дүүргийн Засаг даргын 2025 оны 02 сарын 05-ны өдрийн А/34 дүгээр захирамжаар 3,000,000 төгрөг шийдвэрлэв.
7	Гомдол	<p>Иргэн, аж ахуй нэгжээс 5 гомдол ирүүлснийг шийдвэрлэв.</p> <p>1. Сүхбаатарын талбайн өмнө байрлах хорт хавдрын хөшөөг буулгаж өгнө үү гэсэн гомдол ирсэн.</p> <p>Тус хөшөөг Ази Европийн АСЕМ-ийн дээд түвшний 11 дэх удаагийн чуулга уулзалтыг амжилттай зохион байгуулж, уулзалтын дурсалд зориулж 2016 онд байршуулсан бөгөөд он цаг, түүхэн ач холбогдолоос хамааран түүх соёлын дурсгалд бүртгэлгүй, улс, нийслэл, дүүргийн хамгаалалтанд ороогүй байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газар хөшөөг буулгах эрх бүхий байгууллага биш тул Соёлын өвийн үндэсний төв, соёл урлагийн газарт мэдэгдэж, судлуулах талаар хариу өглөө.</p> <p>2. 10 дугаар хорооны 21-р байранд өдөр өнжүүлэх газар үйл ажиллагаа явуулснаас амгалан тайван байдал алдагдаж, орон сууц биш сургууль цэцэрлэг шиг байгаад гомдол ирүүлсэн.</p> <p>Өдөр өнжүүлэх үйл ажиллагаа явуулж буй иргэн болон өргөдөл гаргагчтай биечлэн уулзаж, зөвлөмж өгч ажиллав.</p> <p>3. 16-р сургууль 2-р улирлын хичээл эхэлснээс хойш халаалтгүй болж, хичээл нь цахимд шилжиж байна. Төвийн дулааны шугамаас халаалт олгох боломжгүй гэсэн мэдээлэл өгсөн байна. Энэ асуудлыг яаралтай шийдэж хариу өгнө үү гэсэн гомдол 3 удаа ирүүлсэн.</p> <p>Өргөдлийн дагуу 6 удаагийн шуурхай үйл ажиллагааг зохион байгуулан 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 03:00 цагт 16 дугаар сургуулийн халаалтын шугамыг засварлаж, мөн өдрийн 13:30 цагаас 2-р ээлжийн хичээл танхимаар хичээллүүлж, сургалтын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж байна.</p>

Хүүхдийг үрчлүүлэх 9, асран хамгаалагч, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд харгалzan дэмжигч тогтоох 11 шийдвэр тус тус гаргаж, хүний эрхийг хангаж ажилласан.

2025 оны 01 дүгээр улиралд өөрийн гэсэн гэр оронгүй, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас орон гэргүй болсон 1 өрхөд Засаг даргын шийдвэрээр гэр олгож, амьдралын чанарт дэмжлэг үзүүлсэн.

Буцалтгүй мөнгөн тусламж хүссэн 2 иргэнд дүүргийн Засаг даргын захирамжаар нийт 6,000,000 сая төгрөгний буцалтгүй мөнгөн тусламж олгож, эрүүл мэнд болон хүний хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааг зохион байгуулсан.

Гэр, буцалтгүй мөнгөн тусламж хүссэн 4, хүүхдийг үрчлүүлэх хүсэлт ирүүлсэн 1 өргөдлийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрийг албажуулахаар захирамжийн төсөлд санал авч байна.

2025 оны 01 дүгээр улирлын байдлаар нийт 35 өргөдөл хүлээн авч 4 хоног 01 цаг 13 минут хугацаанд шийдвэрлэж ажилласан.

Хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлууд

Тус хэлтэст хандаж иргэдээс худалдаа, үйлчилгээний чанар аюулгүй байдлын талаар 6, хоол үйлдвэрлэл, орон сууцны 1 дүгээр давхрын үйлчилгээний талаар 1, нийтийн эзэмшилийн зам талбайд байрлуулсан ТҮЦ-ийн талаар 2, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилэх тусгай зөвшөөрөл, тамхины зөвшөөрлийн хүсэлт илгээх цахим системийн талаар 2, нийт 11 өргөдөл, гомдлыг барагдуулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Худалдаа, үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний чанар, аюулгүй байдал, стандартын шаардлага зөрчсөн гомдол мэдээллийн дагуу НХХААГ-ын Хяналтын хэлтэстэй хамтран үбрчил гаргасан аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын байранд хяналт тавьж, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд хүнсний аюулгүй байдал, үйлчилгээний стандартыг хэрхэн ханган ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөрчлийг арилгуулсан.

Гар дээрх ил задгай худалдаа, үйлчилгээ, ТҮЦ-ийн үйл ажиллагааг цэгцлэх ажлын хүрээнд дүүргийн Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэс, хороодын ажлын албадтай хамтран хяналт шалгалт явуулж, зөвшөөрөлгүй ил задгай худалдааг зогсоож, нийтийн эзэмшилийн зам талбайд байрлуулсан ТҮЦ-ийг нүүлгэж, газар чөлөөлөх ажлыг дүүргийн Газар, зохион байгуулалтын албатай хамтран 6 ТҮЦ-д Мэдэгдэл хүргүүлэн, газар чөлөөлөх арга хэмжээ аван ажиллаж байна.

Зөвшөөрлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журмын дагуу худалдаа, үйлчилгээ эрхлэх хүсэлт илгээхэд шаардагдах бичиг баримтуудыг “Онлайн бизнес төв” цахим системээр авч байгаа бөгөөд Засгийн газрын хэрэг эрхлэх газраас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу зөвшөөрөл шаардахгүйгээр эрхлэх худалдаа, үйлчилгээнд тавигдах шаардлагуудыг хялбаршуулах чиглэлээр УБЗАА, НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газартай хамтран ажиллаж байна.

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

В.ГОМБОДОРЖ

ТАЙЛАН ГАРГАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.ЧИМЭДДУЛАМ